



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 09

Чингис хот

┌ Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай ┐

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.5, 2009 оны 99 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.1, 6.2, 6.2.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Томилох эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэлтэй Л.Хэрлэнтуяа, Д.Дагмидмаа, Г.Хэрлэн, Ш.Отгонцэцэг нарыг Хэнтий аймаг дахь Бор-Өндөр сумын сум дундын Шүүхийн шүүгчийн туслахын, П.Энхмааг Хэнтий аймаг дахь Бор-Өндөр сумын Шүүхийн тамгын газрын мэдээлэл, лавлагааны мэргэжилтний ажлын байранд тус тус санал болгосугай.

2. Энэхүү тогтоолыг Бор-Өндөр сум дахь сум дундын Шүүхийн Тамгын газрын дарга /Л.Наянтай/-д хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР